ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/17 Сайншанд

Ногоон сум дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дах хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих "Ногоон сум" дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц үр дүнг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625013035

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/17 дугаар тогтоолын нэгдүгээр
хавсралт

“НОГООН СУМ” ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний өрнүүлэх

1.2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3 дахь заалт

1.3. “Алсын хараа-2050” Монгол Улсыг урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн “Ногоон хөгжил” зорилтийг хэрэгжүүлэх

1.4. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийг хэрэгжүүлэх

1.5. Сэврэй сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Байгаль орчин аялал жуулчлалын салбарын өсөлт” заалтыг хэрэгжүүлэх.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ, шаардлага

Уур амьсгалын өөрчлөлт гэж удаан хугацааны дотор (хэдэн арван жил, түүнээс дээш) уур амьсгалын дундаж төлөв байдлын аль нэг үзүүлэлтийн статистик үнэмшилтэй өөрчлөлтийг хэлнэ. Уур амьсгалын өөрчлөлт нь байгалийн дотоод болон гадаад хүчин зүйлийн нөлөө, түүний дотор хүний үйл ажиллагааны улмаас үүснэ.

Цөлжилт гэдэг нь хуурай, хагас хуурай ба гандуу, чийг дутмаг нутаг дэвсгэрт уур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагаатай холбоотой олон төрлийн хүчин зүйлээс үүдэлтэй газар буюу газрын бүрхэвчийн доройтол хэмээн НҮБ-ын Цөлжилттэй Тэмцэх Конвенцид тодорхойлжээ.

Цөлжилттэй тэмцэх, цөлжилт уур амьсгалын өөрчлөлийг сааруулах гэж цөлжих эрсдэлтэй газар нутгийг цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, элсний нүүлтийг зогсоох, тариалангийн талбайн хөрс хамгаалах, ойн зурвас байгуулах, бэлчээрийн даацыг тохируулах болон цөлжиж байгаа, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээх, мод, бут тарих, ургамалжуулах, усан сан байгуулах, булаг шанд хаших, гангийн нөлөөг бууруулах хүлэмжийн хийг багасгах зэрэг үйл ажиллагаануудын нэгдлийг хэлнэ.

Уур амьсгалын үндсэн үзүүлэлт болох агаарын дундаж температур, хур тунадасны сүүлийн 10 жилийн дундажийг олон жилийн дундажтай харьцуулсан судалгааг аймгийн түвшинд хийж үзэхэд нийт нутгаар агаарын температур хүйтэндээ -11,5^{0}C -аас -16,8^{0}C байна. Дулаан үеийн үргэлжлэх хугацаа нь 188 хоног орчим байдаг байна. Сүүлийн 60 жилд орсон хур тунадасны жилийн нийлбэр утга Өмнөговь аймгийн нутгаар жилд 0.11-0.92 мм -ээр буурсан нь агаарын температур нэмэгдэж, дулаарч байгаа явцтай хавсран ган болох эх үүсвэр болохын зэрэгцээ, бэлчээр доройтох үндсэн нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн жилд шуурах шороон шуургатай өдрийн тоо аймгийн дундажаар 19-55 хоног байгаа нь хуурайшилтыг эрчимжүүлж байна.

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн уур амьсгал нь хуурай сэрүүвтэр, хуурай дулаавтар, нэн хуурай дулаан мужид хуваагдах бөгөөд Сэврэй сумын нутаг дэвсгэр дээрх 3 мужид багтдаг байна. Хөрс нь механик бүрэлдэхүүний хувьд хөнгөн буюу элсэнцэр 72,8

хувийг эзэлдэг бөгөөд ихэвчлэн давсны төрлийн ургамал ургах нөхцөлтэй. Бэлчээрт ашиглагдаж байгаа хөрсний дийлэнхи хэсэг нь цөлийн бор саарал хөрс, цөлөрхөг хээрийн цайвар бор, цөлөрхөг хээрийн бор хөрсүүд байдаг байна.

Уур амьсгалын өөрчлөлтийг дагаад усны нөөц, хур тунадасны хэмжээ багасч, агаарын температурын өсөлтөөс газрын гадаргын ууршиц нэмэгдэж, орох хур тунадас үүнийг нь нөхөх хэмжээнд хүрч чадахгүй байгаа нь говь нутгийн булаг шанд, баянбүрд ширгэх зэрэг олон сөрөг нөлөөлөл бий болж, гүний усны түвшин харьцангуй багасч байна.

Хуурайшилтийн нөлөөллөөс болж гол горхи, булаг шанд, нуур цөөрөм хатаж ширгэн, бэлчээрийн ургамлын ургац буурч, зүйлийн бүрдэл нь хомсдож байна. Бэлчээр доройтох, хэт халуун өдрийн тоо нэмэгдсэнээс мал сүрэг зун намартаа тарга хүчээ бүрэн авч чадахгүй давжааран зудын гамшгийг тэсвэрлэх чадвар нь буурч байна. Мөн нийт хүн амын дунд уур амьсгалын өөрчлөлт хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг үр дагаврын талаарх ойлголт, мэдлэг таарууй байна.

Сумын нутаг дэвсгэрийн 83 хувь нь улсын тусгай хамгаалалтад үлдсэн хувь нь орон нутгийн хамгаалалтад байгаа бөгөөд газрын доорх усны нөөц бүрэн судлагдаагүй байна. Хөрсний эвдрэл, бэлчээрийн доройтол, тоосжилт, ургамлын гарц багасах, ургац муудах, худаг ус ширгэх, цөлжилт нэмэгдэх хандлагад анхаарал хандуулж, сумын төвийн усан хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, хүн амын ундны усны эрүүл, аюулгүй байдлыг хангах, тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжих, булаг шандны эхийг хашиж хамгаалах, эвдрэлд орсон талбайг нөхөн сэргээх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгцээ байна.

Ногоон сум дэд хөтөлбөрийг 2015-2021, 2022-2024 оны хугацаанд хэрэгжүүлэн 90-аас дээш хувьтай дүгнүүлэн ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд мод бут тарих, хөрс хамгаалах, нөхөн сэргээх, булаг шанд хашиж хамгаалах, хөв цөөрөм байгуулах, ойн зурвас байгуулах зэрэг олон ажлууд үр дүнтэй хийгдсэн. Иймээс жил бүр хөтөлбөр дээр төсөв тавьж, хөтөлбөрийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Ногоон орчинг нэмэгдүүлэн усны зөв хэрэглээг төлөвшүүлж, хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулан цөлжилттэй тэмцэж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Экологийн боловсрол олгох сургалтыг иргэд, идэвхтэн байгаль хамгаалагч, байгаль хамгаалах клуб, нөхөрлөл, төрийн бус байгууллагад зохион байгуулан мэдлэг, чадавхийг дээшлүүлэх

4.2. Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, газрын доорх усны нөөцийн судалгаа хийлгэх, уст цэгийн тоо бүртгэлийн ажил зохион байгуулах, төв суурин газрын ундны усны чанарыг сайжруулах.

4.3. Сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойн зурвас байгуулах, мод тарих хөдөлгөөнийг өрнүүлэх, заган ойг хамгаалах, байгалийн сэргэн ургалтад нөлөөлөх

4.4 Хог хаягдлын менежментийг сайжруулах, хөрсний доройтлыг бууруулах, газар нутгийг хамгаалалтад авах саналыг хүргүүлэх.

4.5 Биологийн төрөл зүйлийг хамгаалах, иргэд, байгаль хамгаалах клуб, нөхөрлөл, төрийн бус байгууллагыг байгаль хамгаалах арга хэмжээнд татан оролцуулах, урамшуулах

4.1. "Экологийн боловсрол олгох сургалтыг иргэд, идэвхтэн байгаль хамгаалагч, байгаль хамгаалах клуб, нөхөрлөл, төрийн бус байгууллагад зохион байгуулан мэдлэг, чадавхийг дээшлүүлэх" 1 дүгээр зорилтын хүрээнд

4.1.1. Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл "Хатан Сэврэйн мэдээ" сонингоор дамжуулан иргэдэд байгаль орчныг хамгаалах талаар мэдээлэл хүргэх

4.1.2. Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдээр дамжуулан иргэд, ЕБС-ийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүдэд ус, ой, амьтны талаар мэдээлэл өгөх

4.1.3. Багийн Иргэдийн нийтийн хурлаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх

4.2. "Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, газрын доорх усны нөөцийн судалгаа хийлгэх, уст цэгийн тоо бүртгэлийн ажил зохион байгуулах, төв суурин газрын ундны усны чанарыг сайжруулах" 2 дугаар зорилтын хүрээнд

4.2.1. Уст цэгийн тоо бүртгэлийг зохион байгуулан мэдээллийн санд бүртгүүлэх

4.2.2. Уст цэгийн хамгаалалтын бүс тогтоох

4.2.3. Булаг шандны эхийг хашиж хамгаалан тохиромжтой байршилд хөв цөөрөм байгуулах

4.2.4. Газрын доорх усны нөөцийн судалгааг хийлгэх

4.2.5. Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ашиглаж буй усны эх үүсвэрийг тоолууржуулах, гэрээ байгуулан ус ашигласны төлбөрийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх

4.2.6. Сайншандын задгайг түшиглэн хөв байгуулан тохижуулах

4.2.7. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт ус цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах

4.2.8. Шинээр гаргасан ундны усны нөөцийн худгийг төвлөрсөн системтэй холбох ажлыг эхлүүлэх

4.2.9. Уст цэгийн мониторингийн судалгааг хийх

4.3. "Сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойн зурвас байгуулах, мод тарих хөдөлгөөнийг өрнүүлэх, заган ойг хамгаалах, байгалийн сэргэн ургалтад нөлөөлөх" 3 дугаар зорилтын хүрээнд

4.3.1. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, сумын ногоон массын хэмжээг нэмэгдүүлэх

4.3.2. Мод тарих санал санаачлага гаргасан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин хамтран ажиллах

4.3.3. Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгжийг аймгийн мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгжид олгох урамшуулалд хамруулах

4.3.4. Хашаандаа сайхан амьдаръя хөтөлбөрт айл өрхийг хамруулах

4.3.5. Булаг шанд, хөв цөөрмийг түшиглэн ойн зурвас байгуулах

4.3.6. Сумын төвд нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг бий болгож, баг байгууллагын нэрэмжит төгөл байгуулах

4.3.7. Хонгорын голд үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч жуулчны баазууд ногоон байгууламжтай болгох

4.3.8. Хонгорын гол, Харайхын голд бургас тариалах ажлыг үргэлжлүүлэн хийх

4.3.9. Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг тогтмолжуулан баруун бүсийг тарьц суулгацаар хангах

4.3.10. Байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжих ажлыг зохион байгуулах

4.3.11. Гүн өрмийн худаг эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжүүд худгаа түшиглэн мод, бут тарих

4.3.12. Нутгийн унаган модлог, бутлаг ургамлын үрийн нөөцийг бүрдүүлэх, ойжуулалтад ашиглах

4.3.13 Ховордсон ургамлыг хамгаалах, тарималжуулах хүсэлтэй иргэдийг бодлогоор дэмжих

4.4. “Хог хаягдлын менежментийг сайжруулах, хөрсний доройтлыг бууруулах, газар нутгийг хамгаалалтад авах саналыг хүргүүлэх” 4 дүгээр зорилтын хүрээнд

4.4.1. Хогийн цэгийг шинээр байгуулах, хуучин хогийн цэгийг дарж булшлах.

4.4.2. Хоёрдогч түүхий эдийг ангилан ялгаж, дахин боловсруулах газарт хүргэх, хоёрдогч түүхий эдийг ашиглан дахин боловсруулсан бүтээгдэхүүн хийх боломжийг судлах

4.4.3. Сумын төвийн болон аялал жуулчлалын бүсийн хог цэвэрлэгээг зохион байгуулах

4.4.4. Хонгорын голын хогийн менежментийг сайжруулж хогийн машин, хог шатаах зуухаар хангах

4.4.5. Аялал жуулчлалын бүсийн хогийн цэгийн ашиглалтыг сайжруулах, хамгаалалт хийх

4.4.6. ЕБС-ийн клубүүдтэй хамтран хог хаягдлын талаар иргэдэд нөлөөлөх ажил зохион байгуулах

4.4.7. Хонгорын голд бохир ус хаях цэгийг стандартын дагуу хийх

4.4.8. Нийтийн эзэмшлийн болон гэр хорооллын нүхэн жорлонгийн тоог багасгах

4.4.9. Бохир сорох машин шинэчлэх

4.4.10. Хөрсний эвдрэл бүхий газар техникийн нөхөн сэргээлт хийх

4.4.11. Сумын нийт газар нутгийн ургамлын нөөц, бэлчээрийн даацын үнэлгээг хийлгэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох

4.4.12. Сумын төв, Балгантыг Даланзадгад-Гурвантэс чиглэлийн авто замтай засмал замаар холбох

4.4.13. Сумын газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авсан шийдвэрүүдийн хугацаанд хяналт тавин ажиллаж, зарим газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах санал асуулгыг иргэдийн дунд зохион байгуулах, саналыг ИТХ-аар хэлэлцүүлэн холбогдох газарт хүргүүлэх

4.5. “Биологийн төрөл зүйлийг хамгаалах, иргэд, байгаль хамгаалах клуб, нөхөрлөл, төрийн бус байгууллагыг байгаль хамгаалах арга хэмжээнд татан оролцуулах, урамшуулах” 5 дугаар зорилтын хүрээнд

4.5.1. Хээрийн амьтдад биотехникийн арга хэмжээ авах

4.5.2. Хээрийн амьтдад зориулсан худгийг засварлаж, ашиглалтыг сайжруулах

4.5.3. Уулын болон талын туруутны тооллогыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

4.5.4. Сурагчдын “Эх орон миний говь” аяллыг зохион байгуулах

4.5.5. Идэвхтэн байгаль хамгаалагчдыг ажлын үр дүнгээр урамшуулах

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт, удирдлага зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийг 2025-2028 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.2.1. Улсын төсөв

5.2.2. Орон нутгийн төсөв

5.2.3. Орон нутгийн хөгжлийн сан

5.2.4. Уул уурхайн компаниудын хандив, тусламж

5.2.5. Иргэд хувийн хэвшлийн дэмжлэг

5.2.6. Бусад

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг сумын Засаг Даргын Тамгын Газар хариуцан,

холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн

6.1. Иргэд, байгаль хамгаалах чиглэлийн клуб, нөхөрлөл, төрийн бус байгууллага, сургуулийн сурагчид, байгаль хамгаалах, байгаль орчны мэдлэгтэй болсон байна.

6.2. Гадаргын усны нөөцийг хамгаалан хуримтлуулж, усыг зүй зохистой ашиглан төв суурин газрын ундны усны найдвартай эх үүсвэртэй болсон байна.

6.3. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж болон ойн зурвас, байгалийн заган ойн талбай нэмэгдэж, иргэд үр шимээ өгдөг мод, бут тарих хүсэл сонирхолтой болсон байна.

6.4. Төв суурин газрын болон аялал жуулчлалын бүсийн хог хаягдлын менежмент сайжирч, хөрсний бохирдол, хөрсний эвдрэл багассан байна.

6.5. Биологийн төрөл зүйлийг хамгаалан байгаль хамгаалах арга хэмжээнд ард иргэд сан дурааараа оролцдог болсон байна.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүтэн жилээр сумын ИТХ-д тайлагнана.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр үнэлж, хөтөлбөрийн эцэст дүгнэнэ.

7.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд сумын ИТХ-ын Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн хороо хяналт тавьж ажиллана.

Найм. Ногоон сум дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хэрэгжүүлэх хугацаа

Ногоон орчинг нэмэгдүүлэн усны зөв хэрэглээг төлөвшүүлж, хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулан цөлжилттэй тэмцэж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

№	Төсөл арга хэмжээний нэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2024 он/	Зорилтот түвшин			
				2025 он	2026 он	2027 он	2028 он
1. Экологийн боловсрол олгох сургалтыг иргэд, идэвхтэн байгаль хамгаалагч, байгаль хамгаалах клуб, нөхөрлөл,төрийн бус байгууллагад зохион байгуулан мэдлэг, чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд							
1	1.1. Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл "Хатан Сэврэйн мэдээ" сонингоор дамжуулан иргэдэд байгаль орчныг хамгаалах талаар мэдээлэл хүргэх	Мэдээллийн тоо	8	6	6	6	6
2	1.2. Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдээр дамжуулан иргэд, ЕБС-ийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүдэд ус, ой, амьтны талаар мэдээлэл өгөх	Арга хэмжээний тоо	4	4	4	4	4
3	1.3. Багийн Иргэдийн нийтийн хурлаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх	Мэдээлэл өгсөн тоо	2	4	4	4	4
2. Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах, газрын доорх усны нөөцийн судалгаа хийлгэх, уст цэгийн тоо бүртгэлийн ажил зохион байгуулах, төв суурин газрын ундны усны чанарыг сайжруулах зорилтын хүрээнд							
4	2.1. Уст цэгийн тоо бүртгэлийг зохион байгуулан мэдээллийн санд бүртгүүлэх	Тоо бүртгэлийн тоо	1	-	-	1	-

5	2.2. Уст цэгийн хамгаалалтын бүс тогтоох	Хамгаалалтын бүс тогтоосон уст цэгийн тоо	-	2	2	2	2
6	2.3. Булаг шандны эхийг хашиж хамгаалан тохиромжтой байршилд хөв цөөрөм байгуулах	Байгуулсан хөв цөөрмийн тоо	1	1	-	1	-
7	2.4. Газрын доорх усны нөөцийн судалгааг хийлгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	-	-	100
8	2.5. Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ашиглаж буй усны эх үүсвэрийг тоолууржуулах, гэрээ байгуулан ус ашигласны төлбөрийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх	Байгуулсан ус ашиглах гэрээний тоо	2	6	6	6	6
9	2.6. Сайншандын задгайг түшиглэн хөв байгуулан тохижуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	-	-	100	-
10	2.7. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт ус цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	-	-	100	-
11	2.8. Шинээр гаргасан ундны усны нөөцийн худгийг төвлөрсөн системтэй холбох ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	-	100	100	-
12	2.9. Уст цэгийн мониторингийн судалгааг хийх	Мониторингийн мэдээний тоо	-	10	12	12	12
3. Сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойн зурвас байгуулах, мод тарих хөдөлгөөнийг өрнүүлэх, заган ойг хамгаалах, байгалийн сэргэн ургалтад нөлөөлөх зорилтын хүрээнд							
13	3.1. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулж, сумын ногоон массын хэмжээг нэмэгдүүлэх	1. Зохион байгуулсан арга хэмжээний тоо 2. Тарьсан модны тоо	1. 2 2. 18100	1. 2 2. 15000	1. 2 2. 20000	1. 2 2. 23000	1. 2 2. 25000
14	3.2. Мод тарих санал санаачлага гаргасан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин хамтран ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	100	100	100
15	3.3. Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгжийг аймгийн мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгжид олгох урамшуулалд хамруулах	Урамшуулалд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	17	15	15	16	16
16	3.4. Хашаандаа сайхан амьдаръя хөтөлбөрт айл өрхийг хамруулах	Хөтөлбөрт хамрагдсан өрхийн тоо	5	3	3	3	3
17	3.5. Булаг шанд, хөв цөөрмийг түшиглэн ойн зурвас байгуулах	Ойн зурвасын тоо	-	1	-	1	-
18	3.6. Сумын төвд нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг бий болгож, баг байгууллагын нэрэмжит төгөл байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-	100	100	100
19	3.7. Хонгорын голд үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын	Ногоон байгууламж	2	2	2	-	-

	үйл ажиллагаа эрхлэгч жуулчны баазуудыг ногоон байгууламжтай болгох	байгуулсан баазын тоо					
20	3.8. Хонгорын гол, Харайхын голд бургас тариалах ажлыг үргэлжлүүлэн хийх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	100	100	100
21	3.9. Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг тогтмолжуулан баруун бүсийг тарьц суулгацаар хангах	1. Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь 2. Бэлтгэсэн тарьц, суулгацын тоо	1. 100 2. -	1. 100 2. 200000	1. 100 2. 200000	1. 100 2. 150000	1. 100 2. 150000
22	3.10. Байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжих ажлыг зохион байгуулах	1. Талбайн хэмжээ, га 2. Загийн суулгацын тоо	1. 10 2. 7500	1. 2 2. 6000	1. 2 2. 6000	1. 2 2. 6000	1. 10 2. 6000
23	3.11. Гүн өрмийн худаг эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжүүд худгаа түшиглэн мод, бут тарих	Үйл ажиллагааний хэрэгжилт, хувь	-	100	100	100	100
24	3.12. Нутгийн унаган модлог, бутлаг ургамлын үрийн нөөцийг бүрдүүлэх, ойжуулалтад ашиглах	Үйл ажиллагааний хэрэгжилт, хувь	-	100	100	100	100
25	3.13 Ховордсон ургамлыг хамгаалах, тарималжуулах хүсэлтэй иргэдийг бодлогоор дэмжих	Үйл ажиллагааний хэрэгжилт, хувь	-	100	100	100	100
	4. Хог хаягдлын менежментийг сайжруулах, хөрсний доройтлыг бууруулах, газар нутгийг хамгаалалтад авах саналыг хүргүүлэх зорилтын хүрээнд						
26	4.1. Хогийн цэгийг шинээр байгуулах, хуучин хогийн цэгийг дарж булшлах	1. Шинээр байгуулсан хогийн цэгийн тоо 2. Дарж булшилсан хогийн цэгийн тоо	-	1. 1 2. -	-	1. - 2. 1	-
27	4.2. Хоёрдогч түүхий эдийг ангилан ялгаж, дахин боловсруулах газарт хүргэх, хоёрдогч түүхий эдийг ашиглан дахин боловсруулсан бүтээгдэхүүн хийх боломжийг судлах	Үйл ажиллагааний хэрэгжилт, хувь	-	100	100	100	100
28	4.3. Сумын төвийн болон аялал жуулчлалын бүсийн хог цэвэрлэгээг зохион байгуулах	Хог цэвэрлэгээний тоо	5	6	6	6	6
29	4.4. Хонгорын голын хогийн менежментийг сайжруулж хогийн машин, хог шатаах зуухаар хангах	1. Үйл ажиллагааний хэрэгжилт, хувь 2. Шатаах зуухний тоо 3. Хогийн машины тоо	1. 100 2. – 3. –	1. 100 2. 1 3. –	1. 100 2. – 3. 1	1. 100 2. – 3. –	1. 100 2. – 3. –

30	4.5. Аялал жуулчлалын бүсийн хогийн цэгийг ашиглалтыг сайжруулах, хамгаалалт хийх	Үйл ажиллагааний хэрэгжилт, хувь	100	100	100	100	100
31	4.6. ЕБС-ийн клубүүдтэй хамтран хог хаягдлын талаар иргэдэд нөлөөлөх ажил зохион байгуулах	Зохион байгуулсан ажлын тоо	-	1	2	2	2
32	4.7. Хонгорын голд бохир ус хаях цэгийг стандартын дагуу хийх	Бохирын цэгийн тоо	-	-	1	-	-
33	4.8. Нийтийн эзэмшлийн болон гэр хорооллын нүхэн жорлонгийн тоог багасгах	Нүхэн жорлонгийн тоо	8	10	4	5	5
34	4.9. Бохир сорох машин шинэчлэх	Шинэчилсэн машины тоо	-	-	1	-	-
35	4.10. Хөрсний эвдрэл бүхий газар техникийн нөхөн сэргээлт хийх	Талбайн хэмжээ, га	48.18	10	5	2	2
36	4.11. Сумын нийт газар нутгийн ургамлын нөөц, бэлчээрийн даацын үнэлгээг хийлгэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	-	100	-	-
37	4.12. Сумын төв, Балгантыг Даланзадгад-Гурвантэс чиглэлийн авто замтай засмал замаар холбох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	–	100	-
38	4.13. Сумын газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авсан шийдвэрүүдийн хугацаанд хяналт тавин ажиллаж, зарим газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах санал асуулгыг иргэдийн дунд зохион байгуулах, саналыг ИТХ-аар хэлэлцүүлэн холбогдох газарт хүргүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	100	100	100
5. Биологийн төрөл зүйлийг хамгаалах, иргэд, байгаль хамгаалах клуб, нөхөрлөл, төрийн бус байгууллагыг байгаль хамгаалах арга хэмжээнд татан оролцуулах, урамшуулах							
39	5.1. Хээрийн амьтдад биотехникийн арга хэмжээ авах	1. Биотехникийн арга хэмжээний тоо 2. Өвсний тоо, боодол	1. 5 2. 600	1. 2 2. 200	1. 2 2. 200	1. 2 2. 200	1. 2 2. 200
40	5.2. Хээрийн амьтдад зориулсан худгийг засварлаж, ашиглалтыг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	100	100	100
41	5.3. Уулын болон талын туруутны тооллогыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Зохион байгуулсан тооллогын тоо	1	1	1	1	1
42	5.4. Сурагчдын "Эх орон миний говь" аяллыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	100	100	100
43	5.5. Идэвхтэн байгаль хамгаалагчдыг ажлын үр дүнгээр урамшуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	100	100	100

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/17 дугаар тогтоолын хоёрдугаар
хавсралт

НОГООН СУМ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Сумын Засаг даргын орлогч

Гишүүдэд: Ц.Амарсанаа (Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Сайншанд багийн Засаг дарга

Хоолт багийн Засаг дарга

Бүйлсэн багийн Засаг дарга

Сэврэй сум дахь сум дундын ойн ангийн дарга

Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын Ирвэс хэсгийн ахлагч

Цаг уурын ажиглагч

Нарийн бичиг: Засаг даргын Тамгын газрын Байгаль хамгаалагч

---000---